




Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн
20 тоот Тогтоолын Хавсралт



**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ
ХУРАЛДУУЛАХ ЖУРАМ
ИС-86 V-1.0**

2022 он

<p><i>Хамрах хүрээ:</i> ИНВЕСКОР ББСБ ХК түүний охин компаниуд</p>	<p><i>Хариуцах эзэн:</i> Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга</p>
<p><i>Хувийг хадгалах:</i> Төлөөлөн удирдах зөвлөл, Хууль, Эрсдэлийн Удирдлагын Газар</p>	<p><i>Танилцах:</i> ИНВЕСКОР ББСБ ХК болон охин компанийн бүх ажилтан</p>
<p><i>Хүчинтэй хугацаа:</i> 2022 оны 06-р сарын 22-ны өдрөөс эхлэн</p>	<p><i>Хуудасны тоо:</i> 9 хуудас</p>
<p><i>Дараагийн үнэлгээ хийх огноо:</i> 2023 оны 06 сарын 22-ны өдөр</p>	
<p><i>Журмын дугаар:</i> ИС-86</p>	<p><i>Хувилбар:</i> V-1.0</p>

Өөрчлөлтийн түүх

#	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1.	V-1.0	2022.06.22	Анх боловсруулсан.
2.			
3.			
4.			
5.			

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	4
2. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗАРЛАХ.....	4
3. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ.....	5
4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ОРОЛЦОХ.....	6
5. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ.....	6
6. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ.....	7
7. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ.....	9
8. <u>ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР ГАРГАХ</u>	9
9. <u>БУСАД</u>	10

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Инвескор ББСБ” ХК /цаашид “ББСБ” гэх/-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлах, хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоох, хувьцаа эзэмшигчид хуралд оролцох, саналаа өгөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмаар зохицуулаагүй ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах үйл ажиллагаанд Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Компанийн засаглалын кодекс, Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, ББСБ-ын Дүрэм болон бусад журмуудыг мөрдөж ажиллана.

ХОЁР. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗАРЛАХ

- 2.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна. Энэ хугацаанд хуралдаагүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасан журмыг баримтлан Хувьцаа эзэмшигчдийг хурлыг зарлан хуралдуулна.
- 2.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэг болон ББСБ-ын Дүрэмд заасан үндэслэлээр Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэдийд ч зарлан хуралдуулж болно.
- 2.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах мэдээллийг тусгана. Үүнд:
 - 2.3.1. Хурал зохион байгуулах хэлбэр;
 - 2.3.2. Хурал болох газар /танхимаар зохион байгуулах бол/;
 - 2.3.3. Хурал болох өдөр, цаг;
 - 2.3.4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
 - 2.3.5. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;
 - 2.3.6. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;
 - 2.3.7. Саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга;
 - 2.3.8. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
 - 2.3.9. Хурлын дарга;
 - 2.3.10. Тооллогын комиссын дарга, гишүүд.
- 2.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш 40-өөс доошгүй хоногийн дараа ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулна.
- 2.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай шууд холбоотой ББСБ-ын эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийг тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.

- 2.6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15-20 дахь өдөр байхаар тогтооно
- 2.7. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлнэ.
- 2.8. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь хуралд оролцоно.
- 2.9. Компанийн тухай хуулийн 64.7, 68.5-д заасантай нийцүүлж, ТУЗ нь бүртгэх өдрөөс хойш хувьцаа худалдан авсан этгээдийг хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдийн бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ

- 3.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад тус тус 2 хоногийн өмнө хүргүүлсний дараа хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.
- 3.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш хуанлийн 5 хоногийн дотор хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.
- 3.3 Журмын 3.2 дахь заалтын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.
- 3.4 ББСБ нь хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг энэ журмын 3.2-т зааснаас гадна утас, факс, электрон шуудан зэрэг холбоо харилцааны боломжит бусад хэрэгслийг ашиглан хувьцаа эзэмшигчдэд хүргэж болно.
- 3.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлын зард дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:
 - 3.5.1 ББСБ-ын оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар;
 - 3.5.2 Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
 - 3.5.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;
 - 3.5.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг;
 - 3.5.5 Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь;
 - 3.5.6 Саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга;
 - 3.5.7 Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
 - 3.5.8 ББСБ-ын дүрэмд заасан болон хурал зарлагч этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

- 3.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ОРОЛЦОХ

- 4.1 Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр, эсвэл Иргэний хуульд заасны дагуу бичгийн хэлбэрээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.
- 4.2 Энэ журмын 4.1 дэх хэсэгт заасны дагуу итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож буй итгэмжлэгдсэн төлөөлөгч нь энэ тухайгаа хурлын бүртгэл явагдаж байх үед ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон тооллогын комиссын даргад мэдэгдэнэ.
- 4.3 Журмын 4.1 дэх хэсэгт заасан итгэмжлэл нь зөвхөн тухайн хуралд хүчинтэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хойшлуулсан боловч тухайн хурлаар хэлэлцэх эер товлосон асуудлыг өөрчлөөгүй тохиолдолд энэ заалт хамаарахгүй.
- 4.4 Саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсонд тооцно.
- 4.5 Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрөөс хойш хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаа бусдад шилжүүлсэн тохиолдолд шинэ эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох итгэмжлэл олгох, эсхүл шинэ эзэмшигчийн өгсөн зааврын дагуу санал өгч болно.
- 4.6 ББСБ-ын нэгж хувьцааг хэд хэдэн этгээд дундаа хэсгээр өмчилж байгаа тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх эрхийг дундаа хэсгээр өмчлөгчдийн харилцан тохиролцсоноор хэн нэг нь, эсхүл тэдний төлөөлөгч хэрэгжүүлнэ.
- 4.7 Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд байх тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт заасны дагуу хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэх эрх бүхий этгээд, эсвэл тухайн эрх бүхий этгээдээс томилж, итгэмжлэл олгосон этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоно.
- 4.8 Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцохдоо өөрийн иргэний үнэмлэх, эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг, итгэмжлэлээр төлөөлж буй этгээд нь хууль ёсны итгэмжлэлийг авч ирнэ.

ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

- 5.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг болон Компанийн Дүрэмд хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамруулахаар заасан асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ.
- 5.2. Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
Үүнд:

- 5.2.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- 5.2.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
- 5.2.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
- 5.2.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
- 5.2.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 5.2.6. Хувьцааг хуваах, нэгтгэх;
- 5.2.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- 5.2.8. Хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
- 5.2.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 5.2.10. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх;
- 5.2.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.
- 5.2.12. Компанийн дүрэмд тусгасан бусад асуудлууд.
- 5.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад бусад гэсэн хэсэг байх шаардлагатай бол энэ нь зөвхөн Компанийн тухай хуулийн 62.1-д заасан асуудал байна.
- 5.4. Саналын эрх бүхий энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д заасан журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах эрхийг эдэлнэ.

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 6.1. ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн хурлыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:
 - 6.1.1 Танхимаар;
 - 6.1.2 Зайнаас /мэдээллийн технологи, программ хангамж ашиглан хурлын бүх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах/;
 - 6.1.3 Хосолсон /танхим болон зайнаас/.
- 6.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь журмын 6.1 дэх хэсэгт заасан хурал зохион байгуулах хэлбэрээс сонгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулна.
- 6.3. Хурал зохион байгуулах комисс нь зайнаас буюу цахим хурал зохион байгуулах бол цахим хурлыг зохион байгуулах мэдээллийн технологи, программ хангамжийн талаар дэлгэрэнгүй танилцуулгыг Хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор Хороонд хүргүүлнэ.
- 6.4 Цахим хурал зохион байгуулахад ашиглах мэдээллийн технологи, программ хангамж нь Хорооноос тогтоосон шаардлага, шалгуурыг хангасан байна.

- 6.5. ББСБ нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах тохиолдолд дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:
- 6.5.1 Хуралд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргагчийн биеийн байцаалт, итгэмжлэлээр оролцох этгээдийн итгэмжлэлийг хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалттай тулган баталгаажуулах /Хуралд оролцох эрх бүхий этгээдийг танин баталгаажуулах, мэдээлэл илгээх, нууцлалыг хангах зорилгоор баталгаат цахим шуудан болон гар утасны дугаар зэрэг нэмэлт мэдээллийг шаардаж болно/;
 - 6.5.2 Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан нэвтрэх эрх, нууц үгийг хуралд оролцохоор бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдийн цахим шуудан, эсхүл гар утасны дугаараар дамжуулан илгээх;
 - 6.5.3 Хуралд ашиглах программ хангамжийг ашиглах заавар, зөвлөгөө бүхий мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх;
 - 6.5.4 Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд шуурхай зөвлөгөө, туслалцаа үзүүлэх мэдээлэл харилцааны цахим суваг болон шуурхай утасны дугаар ажиллуулах;
 - 6.5.5 Хурлын материалыг цахим хурал дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор Хорооны мэдээллийн санд хүргүүлэх;
 - 6.5.6 Хурлын материал, хурлын үйл явцын бүтэн дүрс бичлэг, санал хураалтын баримт зэргийг засварлах, өөрчлөх боломжгүй хэлбэрт шилжүүлэн ББСБ-ын цахим архивын баримт болгох.
- 6.6. Хурлыг танхимаар зохион байгуулах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах комисс хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үндэслэн холбогдох баримт бичгийг шалгах замаар саналын хуудсыг олгож, танхим оруулна.
- 6.7. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хосолсон хэлбэрээр явуулах тохиолдолд зайнаас болон танхимаар хурал зохион байгуулахтай холбоотой энэ журмын холбогдох зохицуулалтыг удирдлага болгоно.
- 6.8. Хурал зохион байгуулах комисс нь хувьцаа эзэмшигчдийн хурлын явцад уг хуралд оролцогч бүх хувьцаа эзэмшигч санал бодлоо илэрхийлэх, асуулт асууж, хариулт авах боломжийг бүрдүүлсэн байна.
- 6.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 08:00 цагаас 22:00 цагийн хооронд зохион байгуулна.
- 6.10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 6.10.1. Хурлын ирц /кворум/-ыг тогтоож, хурлын даргад мэдээлэх;
 - 6.10.2. Тухайн хурлын хэлэлцэх асуудал тус бүрээр оролцогч бүрийн саналын эрхийн тоо, төрлийг тогтоох;
 - 6.10.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах асуудалд тайлбар өгөх;
 - 6.10.4. Санал өгөх журмыг тайлбарлах;
 - 6.10.5. Санал өгөх журам болон хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;

- 6.10.6. Санал хураалтыг саналын хуудсаар явуулж байгаа тохиолдолд уг саналын хуудсыг тоолж, хүлээн авах;
- 6.10.7. Санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх;
- 6.10.8. Санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэж, дүнгийн тухай шийдвэр гарган тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хуралд танилцуулах;
- 6.10.9. Саналын хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх.
- 6.11 Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр тооллогын комисст хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулахтай холбоотой энэ журмын 6.10-г зааснаас бусад үүрэг хүлээлгэж болно.
- 6.12 Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.
- 6.13 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, бэлтгэх ажлыг хангахад ББСБ-ын удирдлага болон нийт ажилтнууд нь хурал зохион байгуулах комисст дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үүрэгтэй.
- 6.14 Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангахтай холбоотой зардлыг ББСБ хариуцна.

ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 7.1. ББСБ-ын саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.
- 7.2. Журмын 7.1 дэх хэсэгт заасан ирц бүрдээгүй тохиолдолд тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг Төлөөлөн удирдах зөвлөл тогтоох бөгөөд энэ тохиолдолд хойшлогдсон хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулахгүй. Ийнхүү хойшлогдсон хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд хурал хуралдахаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.
- 7.3. Хойшлогдсон хурлыг зохион байгуулах, хурлын ирцийг тогтоохдоо Компанийн хуулийн 69 дүгээр зүйлд заасныг баримтална.

НАЙМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР ГАРГАХ

- 8.1 Нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тохиолдолд санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.
- 8.2 Хувьцаа эзэмшигчдийн саналыг саналын хуудсаар авна.
- 8.3 Саналын хуудасны агуулгад дараах зүйлсийг заавал тусгана. Үүнд:
 - 8.3.1 ББСБ-ын оноосон нэр;
 - 8.3.2 Хурал хуралдах хэлбэр, газар, өдөр, цаг;
 - 8.3.3 Хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;

- 8.3.4 Санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томъёолол, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
- 8.3.5 Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийг сонгоход хэрэглэх санал хураах аргын нэр /ердийн, кумулятив/.
- 8.4 Саналын хуудсаар өгсөн саналыг дараах тохиолдолд хүчинтэйд тооцно. Үүнд:
- 8.4.1 Ердийн журмаар санал өгөх асуудалд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн;
- 8.4.2 Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийг ердийн журмаар санал хурааж сонгох тохиолдолд нэр дэвшигчийг дэмжсэн санал нь сонгогдох гишүүдийн тооноос илүүгүй байх;
- 8.4.3 Кумулятив аргаар санал хураан сонгох тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшигч бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн саналын эрхийн тооны нийт дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа саналын эрх бүхий энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.
- 8.4.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг нь тэмдэглэсэн байна.
- 8.5 Тооллогын комиссын дарга нь санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулах бөгөөд хэлэлцэх асуудлаас хамааран нийт хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн олонх, эсвэл дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ. Шийдвэр гаргахдаа олонх, эсвэл дийлэнх олонхын саналаар шийдвэрлэх эсэхийг Компанийн Дүрэм болон холбогдох хуульд зааснаар зохицуулна.
- 8.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоол гаргах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, хурлын дарга гарын үсэг зурснаар тогтоол хүчин төгөлдөр болно.
- 8.7 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг дуу, дүрсний бичлэг хийх замаар хадгалах бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор хурлын тэмдэглэлийг бичгийн хэлбэрт буулгаж, хурал даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.
- 8.8 ББСБ нь хурлын шийдвэрийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.8 болон 56.1.6-д заасны дагуу нэн даруй нийтэд мэдээлж, дараах холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ. Үүнд:
- 8.8.1 Ирцийн бүртгэл, итгэмжлэлээр оролцож буй этгээдийн бүртгэл, ирцийн баталгаажилт,
- 8.8.2 Саналын хуудасны хуулбарууд;
- 8.8.3 Тооллогын комиссын дарга, гишүүдийг томилсон шийдвэр;
- 8.8.4 Тооллогын комиссын дарга, гишүүдийн анкет;
- 8.8.5 Тооллогын комиссын шийдвэрүүд;
- 8.8.6 Хурлын тэмдэглэл, хурлын шийдвэрүүд;

- 8.8.7 Шаардлагатай бусад баримтууд.
- 8.9 **Эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах:** Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болох бөгөөд эчнээ санал хураалтыг саналын хуудсыг ашиглан явуулна.
- 8.10 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.
- 8.11 Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргах бөгөөд эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах харилцаанд Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийг удирдлага болгоно.

ЕС. БУСАД

- 9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн талаар хуралд оролцоогүй, эсхүл оролцсон боловч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч дараах үндэслэлээр шүүхэд гомдол гаргаж болно. Үүнд:
- 9.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зарлаагүй;
- 9.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах шийдвэр гарснаас хойш хуралдах өдөр, газрыг өөрчилсөн;
- 9.1.3. Хурлаар хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хэлэлцсэн.
- 9.2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, оролцсон боловч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь Журмын 9.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргах эрхтэй.
- 9.3. Журмын хэрэгжилтэд Төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.
- 9.4. Журмыг зөрчсөн этгээдэд ББСБ-ын дотоод журам болон холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--